

БНСВУ ДАХЬ ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЭЧЛЭЛ

С. Дашцэвэл

Эдүгээ ихэнх ах дүү социалист орнуудад өөр өөрийн онцлогт нийцсэн эдийн засгийн шинэчлэл, өөрчлөн байгуулалт хийж байгаа билээ. БНСВУ-д нийгмийн амьдралын бүх талыг хамарсан шинэчлэл хийж байгаа бөгөөд эдийн засгийн шинэчлэлийн үзэл санаа 1980-аад оны эхээр улс орны хөгжлийн шаардлагаас дэвшин гарч одоо уг шинэчлэлийг тууштай хэрэгжүүлэхийн төлөө тэмцэж байна.

1. Эдийн засгийн сэтгэлгээн дэх зарим шинэчлэл

БНСВУ-д юуны өмнө улс орныхоо хөгжлийн өнөөгийн болон хэтийн зорилтыг шинжлэх ухааны үндэстэй тодорхойлох ажлыг цэгцлэж байна. Үүний тулд хөгжлийн одоогийн үе шатаа зөв тодорхойлох нь нэн чухал хэмээн үзэж,¹ социализмын хөгжлийн үе шатууд, түүний дотор капитализмын өмнөх шатнаас социализмд шилжих шилжилтийн үеийн онцлог хийгээд мөн чанарын талаар багагүй судалгаа, хийж байна.²

1982 оноос эхлэн ВКН-ын их, бүгд хурлуудын баримт бичигт хөгжлийн үе шатны хувьд БНСВУ шилжилтийн үеийн эхний үе шатанд явж буй хэмээн тэмдэглэжээ.³ Хөгжлөөр буурай жижиг үйлдвэрлэл зонхилсон аж ахуйг социалист том үйлдвэрлэл болгон хөгжүүлэх явцыг хэрэгжүүлж буй БНСВУ-ын хувьд шилжилтийн үе харьцангуй удаан үргэлжлэх бөгөөд олон шаттай гэж үзэж байна.⁴

Вьетнамын эрдэмтэд шилжилтийн үе нь социалист байгуулалтын бүрэлдэн тогтох үе буюу тодруулбал социалист шинэ нийгэм, эдийн засаг бодитойгоор бүрэлдэн буй болж бэхжих үе бөгөөд эдийн засгийн мөн чанар нь өөрийн дотоод нөөц боломжинд тулгуурлан социалист байгуулалтын анхны хуримтлалыг буй болгох явдал гэж үзэж байна.⁵ Вьетнамын хувьд социалист байгуулалтын анхны хуримтлал бий болоогүй зөвхөн хэрэгжүүлэх эхлэл төдий байгаа нь шилжилтийн үеийн эхний шатны эдийн засгийн нэг шинжийг тодорхойлж буй ажээ.

БНСВУ дахь шилжилтийн үеийн төгсгөлийн шатны зорилт бусад социалист орнуудынхтай адил төстэй байх⁶ бөгөөд харин хөгжлөөр хоцрогдонгүй орны хувьд эхний шатны зорилт нэлээд өвөрмөц ялгаатай гэжээ. Тухайлбал, БНСВУ шилжилтийн үеийн эхний шатанд юуны өмнө эдийн засгийн байдлыг тогтворжуулах, хүн амыг хүнсний болон өргөн хэрэгцээний бүтээгдэхүүнээр хангах, үүний хамт социалист аж үйлдвэржүүлэлтийг далайцтай өрнүүлэхэд эдийн засгийн зайлшгүй угтвар нөхцөл бий болгох явдал гэж нотолжээ.

Шилжилтийн үеийн эхний шатны эл зорилтыг дутуу ойлгож байснаас улс орныг үйлдвэржүүлэх бодлогыг цорын ганц зорилт болгон тавьж, хүч нөөцийг аж үйлдвэрт хэт төвлөрүүлсэн явдал улс орны хөгжилд бэрхшээл учруулах нэг үндэс болсон ажээ. Иймд эдийн засгийн болон хөрөнгө оруулалтын бүтцийг хянан шинэчилж байна.

Хөдөө аж ахуйн салбарыг түлхүү хөгжүүлж эдийн засгийн зохих хуримтлал бий болгохыг чухалчилж байна.

Тус улсын эдийн засаг ихэнх социалист орнуудаас ялгагдах хэд хэдэн өвөрмөц онцлогтой. Үүний нэг нь өмчийн олон хэлбэр үйлчилж байгаа явдал юм. БНСВУ-д эдүгээ улсын, хоршооллын, улс-хувийн, хувийн, амины өмч байгаа бөгөөд эдгээр өмчийн хэлбэрүүд түр зуурын биш удаан хугацаанд зэрэгцэн орших болно гэж үзэж байна. Тус орны хөгжлийн одоогийн шатанд социалист секторын боломж, чадавхи хязгаарлагдмал байна. Ийм нөхцөлд үйлдвэрлэх хүчнийг бүх талаар хөгжүүлж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд улс орны эдийн засгийн бүх бололцоог дайчлан ашиглахыг гол болгож байна. Эдийн засгийн хэвшлүүдийг ашиглах, өөрчлөх ажилд үйлдвэрлэлийн харилцаа үйлдвэрлэх хүчний хөгжлийн түвшин, шинж чанарт тохирч байх зарчмыг онцгой анхаарахыг чухалчилж байна.

Эдийн засгийн социалист биш секторуудыг хүчээр устгах нь нийгмийн үйлдвэрлэлийн хүчин чадлыг сулруулахад хүргэх учир «өөрчлөн байгуулахын тулд ашиглах, улам сайн ашиглахын тулд өөрчлөх» гэсэн зарчмыг баримталж байна.

Социалист том үйлдвэрлэлийг бий болгох чиглэлээр үйлдвэрлэх хүчнийг хөгжүүлэх нь хэзээ ямагт улс орны стратеги зорилт байх ажээ. Вьетнамд улсын худалдаанаас гадна «Чөлөөт» зах үйлчилж байгаа бөгөөд энэ 2 төрлийн зах зээл нь хоорондоо зөрчилтэй хэдий ч нийгмийн олон талт хэрэгцээг хангахад бие биенээ нөхөж байгаа ажээ. Улсын социалист худалдаа, хүн амын хэрэгцээг бүрэн хангаж чадахгүй байгаа өнөөгийн нөхцөлд «чөлөөт» захыг сөрөг үзэгдэл хэмээн устгахыг хэт яаравчлах, эсвэл түүний хяналтыг сулруулж урсгал чанарт нь хөтлөгдөх хоёрын аль аль нь алдаатай гэж үзэж байна. Вьетнамын эдийн засгийг өнөөгийн хүнд байдлаас гаргаж үйлдвэрлэлийг нэмэгдүүлэн социалист байгуулалтыг тууштай хэрэгжүүлэхэд аж ахуйг удирдах социалист аргыг боловсронгуй болгохын чухлыг зааж байна. Юуны өмнө хөдөө аж ахуй, аж үйлдвэрийн салбарт удирдлагын механизмыг шинэчлэн, захиргаадах аргаас эдийн засгийн аргыг тууштай хэрэгжүүлэхийг улс орны эдийн засгийн тулгамдсан асуудал гэж үзэж байна.

Улс орны эдийн засгийг хөгжүүлэхэд эдийн засгийн гадаад харилцаа чухал нөлөөтэй учраас ВКН-ын VI их хурлаас эдийн засгийн энэ салбарыг үр ашигтай хөгжүүлэхийн чухлыг заажээ. БНСВУ эдийн засгийн харилцан туслах зөвлөлийн орнууд юуны өмнө ЗХУ-тай эдийн засгийн шууд харилцаа, олон хэлбэрийн хамтын ажиллагааг өргөжүүлэх чиг шугамыг тууштай баримталж байна. Үүний хамт социалист биш орнуудтай харилцан ашигтай байх зарчмын үндсэн дээр худалдаа, эдийн засгийн харилцааг өргөжүүлэхийг чухалчилж байна. Үйлдвэрийн газрын хууль, хөрөнгө оруулалтын тухай хууль, экспорт импортын татварын тухай хууль болон бусад хэд хэдэн хууль тогтоомжийг эдийн засгийн шинэ сэтгэлгээнд тулгуурлан шинэчилсэн нь дээрх бодлогыг хэрэгжүүлэх бололцоог улам бодитой болгов.

II. Хөдөө аж ахуй дахь шинэчлэл

1980 онд хөдөө аж ахуйн салбарт гэрээгээр ажиллаж эцсийн бүтээгдэхүүнээр хөлс олгох тухай улс төрийн товчооны (100-р) тогтоол

гарсан нь хөдөө аж ахуйн салбар дахь эдийн засгийн шинэчлэлийн эхлэл болов.

1981 оноос вьетнамын хөдөө аж ахуйн ихэнх хоршоолол гэрээгээр ажиллаж эхэллээ.

Вьетнамын нийслэлээс холгүй оршдог «Хонг Зыонг» хоршоололд 1987 оны дундуур ажлын далимаар очив. Тус хоршоолол 1000 гаруй өрхтэй, 700 га тутрагын талбайтай юм. Хоршооллын тариачид 1881 оноос гэрээгээр ажиллаж эхэлжээ. Тэд тутрага суулгах, тордох ургац хураах, хатааж цайруулах ажлыг гэрээгээр гүйцэтгэж байв. Хоршооллын зөвлөл газрыг нь хагалж, борнойдох, үрээр хангах, усан шахуургаар үйлчлэх (үр суулгах үед тутрагын талбайгаа усаар дүүргэх, ургац хураах үед талбайгаас усыг шавхах хэрэгтэй тул цагаан будааг услах ажиллагаа их хөдөлмөр зарцуулна) төрөл бүрийн бордоогоор хангах ажлыг даах үүрэг авчээ.

Өрхөд хуваарилсан талбайн хөрс харилцан адилгүй тул 3 зэрэгт хувааж түүнд тохирсон төлөвлөгөө өгч байна. I-р зэргийн газарт га тутамд 3 тонн, II зэргийнхэнд 2,5 тонн, III зэргийн газарт 2 тонн тутрагын төлөвлөгөө өгч⁷ илүү авсан ургацыг тариачид өөрөө авах бөгөөд хөдөлмөрийн хөлсөнд ургацынхаа 40% -ийг авдаг, харин мөнгөөр цалин авдаггүй ажээ. Ийнхүү өрхийн гэрээгээр ажиллах болсноор хоршооллын гишүүдийн хөдөлмөрийн идэвх эхний жилүүдэд сэргэжээ.

Өрхийн гэрээгээр ажиллах хөдөлгөөн вьетнамын хөдөө аж ахуйд нэвтэрч эхэлснээс хойшхи эхний 5 жилд үр тарианы үйлдвэрлэл тогтвортой өсчээ. (I-р хүснэгт үз) 1980 онд 1 хүнд оногдох үр тарианы хэмжээ 268 кг байсан бол 1985 онд 309 кг болсон байна. (Энэ хугацаанд вьетнамын хүн ам 5,8 саяар нэмэгдсэн юм).

Хүснэгт № 1

Үр тарианы үйлдвэрлэлийн өсөлт
(сая тонноор)

| Он | 1980 | 1981 | 1982 | 1983 | 1984 | 1985 |
|----------|------|------|------|-------|-------|------|
| Үр тариа | 14,5 | 15,1 | 16,8 | 16,98 | 17,88 | 18,4 |

Гэвч сүүлийн 3 жилд (1986-1988) хөдөө аж ахуйн хөдөлмөрийн бүтээмж төдийлөн өссөнгүй, үр тарианы ургац дундчаар 0,5 сая тон ноор буурч 1 хүнд оногдох хэмжээ нь 309 кг-аас 280 кг болж багасав. Үүнд байгаль цаг уурын тааламжгүй нөхцөл нөлөөлсөн тал буй боловч эдийн засгийн шинэчлэлийн явцад захиргаадах тэгшитгэх арга барил— амь бөхтэй зууралдсаар байгаагийн уршиг гүнзгий нөлөөлжээ. Ялангуяа хуваарилалт, солилцоо, үнэ зах зээлийн хуучин механизм шинэчлэлд сүрхий чөдөр тушаа болжээ. Дайны жилүүдэд хуваарилалт, солилцоо, санхүү зээлийн асуудлыг хэт төвлөрүүлэн шийдэж, цалин хөлс, үнийн системийг эдийн засгийн бус хууль дүрмээр зохицуулж байсныг өөрчлөх үүднээс хэд хэдэн удаа засвар хийсэн боловч олон жилийн хэвшмэл байдлаас ангижирч чадахгүй цаг алдсаар байгааг 1986 онд хуралдсан ВКН-ын VI их хурлаар хурц шүүмжлэв. Ийнхүү аж ахуйн механизмын тодорхой асуудлыг шийдвэрлэхэд урьдын хэвшиж тогтсон сэтгэлгээ, урсгал нөлөөнөөс гадна шинээр

нэвтрүүлж байгаа механизмын эхэн үеийн доголдол ч илрэн гарч байна. Тухайлбал тутрагын талбайг тариачдад гэрээгээр өгсөн хэдий боловч үйлдвэрлэлийн бусад хэрэгсэл (зүтгэх хүч, усжуулах насос гэх мэт) тариачдын гарт шилжээгүй учир үйлдвэрлэлийн гол элемент хүнд хүчир ажлуудыг (газар хагалах, тутрагын талбайд ус татах, ус шавхах гэх мэт) хийхдээ хоршооллын гар харсан хэвээр байна. Энэ нь хөдөлмөрийн үр дүнгийн олон зүйл хоршооллоос хамаарсан хэвээр байна гэсэн үг юм. Үйлдвэрлэлийн эцсийн үр дүн ийнхүү хараат байгаа нь хөдөлмөрөө шинээр зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрэхээ урьдчилан тооцоолж бие даан ажиллах бололцоог хязгаарлаж байна. Тариачдын га-гаас авах ургац гэрээнээс давах нь төдийлөн ихгүй, гэрээлж хийсэн ажлын хөлсөнд авч буй тутрагын хэмжээ ч нэн бага төдийгүй түүний таваарлаг чанар муу байгаа нь тариачдын амжиргааны түвшин дээшлэхэд саад болж байгаа ажээ.

Энэ доголдлыг гэтлэн давахын тулд шинэ шинэ арга зам эрэлхийлж, ах дүү орнуудын туршлагыг ч сонирхон судалж байна.

1987 оноос вьетнамын зарим хоршоолол гэрээгээр ажиллах хэлбэрийнхээ агуулгыг нэлээд баяжуулав. Тухайлбал хоршооллын зөвлөл гэрээнийхээ үүргийг зарим тохиолдолд биелүүлж чадахгүй байгаатай холбогдуулан (газар хагалах, услах техникээр хангаж чадаагүй буюу үрээр тасалсан, шавьж устгагч өгөөгүй гэх мэт) Үүрэг тус бүрд тохирсон төлбөрийн хэмжээг тогтоожээ. Мөн хөдөлмөрийн зарим хэрэгсэл тухайлбал газар зүтгэх хүчийг 5—10 жилээр түрээслэн өгч байна. Үүний дүнд тариачдын сонирхол үлэмж дээшилж, нийгмийн өмчид хүнийрхүү сэтгэлээр хандах явдал арилсан байна. Хаврын буюу өвлийн тариалалт эхлэх үед хоршооллоос тодорхой хэмжээний газрыг үйлдвэрлэлийн бусад хэрэгсэлийн хамт бригад салаагаараа гэрээлэн авч хөлсийг эцсийн үр дүнгээр тооцож авах богино хугацааны гэрээний хэлбэрийг зарим газар хэрэглэж амжилтанд хүрч байна. Гэвч нийт хоршоололд зүтгэх хүч, техник хэрэгсэл, бордоо, үр нэн дутагдалтай байгаа нь түрээсийн хэлбэрийг хөгжүүлэхэд сүрхий саад болж байна.

Вьетнамын хөдөө аж ахуйн салбарт хэрэгжүүлж байгаа гэрээ, түрээсийг хоршоолол тус бүрийн чадвар, боломж, байгаль цаг уурын нөхцөл, аж ахуйн уламжлал зэргийг харгалзан аль болох ашигтай олон хэлбэрээр өрнүүлэхийн чухлыг зааж байна.

Үүнээс гадна Вьетнамын хөдөөгийн оршин суугчид өрхийн уламжлалт аж ахуйгаа чөлөөтэй эрхэлж хөгжүүлэх боломжтой болов. Вьетнамын тариачид өөрийн байгаль, цаг уурын нөхцөлд тохирсон өвөрмөц бүтэц бүхий өрхийн аж ахуйг олон үеийн турш эрхэлж ирсэн билээ. Энэ нь гол аж ахуй болох тутрагын аж ахуйгаас гадна гахай, тахиа, одос үхэр, жимс ногооны цэцэрлэг, загасны цөөрөм зэргээс бүрдэж байна. Жимс ногоо нь тариачин өрхийн өдөр тутмын хэрэгцээнд хэрэглэгдэж, цөөрөм нь хүнсний загас үржүүлэх, ногооны талбай услахад, гэрийн мал одос үхрийг газар хагалахад, гахай шувууны мах өндгийг хүнсэнд, ялгадас сангасыг бордоонд гэх мэтээр хэрэглэдэг харилцан шүтэлцээтэй аж ахуй билээ. Тавьжараад онд хоршооллын хөдөлгөөн өрнөж, тариачдын аж ахуйн уламжлалт энэ бүтэц нэлээд алдагдахад хүрчээ. Эдүгээ өрхийн гэрээгээр үйлдвэрлэл явуулах боломж байгаа нөхцөлд уламжлалт аж ахуйн бүтцийг дахин

сэргээх хандлагатай болж, хоршооллын зөвлөл ч үүнд тусалж байна.

Сүүлийн жилүүдэд хоршооллын зөвлөлөөс амны аж ахуйг хөгжүүлэхийг аль болохоор дэмжиж байна. Үүний үр дүнд Вьетнамын нийт мал, гэрийн тэжээмэл амьтны тоо толгой ч мэдэгдэхүйц өсөв.

**Вьетнамын мал, гэрийн тэжээмэл
амьтны өсөлт (сая, толгойгоор)**

| Малын нэр | 1980 | 1985 |
|-----------|------|------|
| Үхэр | 1,6 | 2,6 |
| Одос | 2,3 | 2,6 |
| Гахай | - | 12,6 |
| Шувуу | 69 | 100 |

Хүснэгтэд дурдсан хугацаанд махны үйлдвэрлэл 2,2 дахин, өндөг 1,7 дахин нэмэгджээ. 1 хүнд оногдох махны хэмжээ 1980 онд 8,3 кг байсан бол 1986 онд 12,5 кг болов.

Вьетнамын олон хоршоолол хөдөлмөрийн нөөцөө бүрэн ашиглахын тулд гар үйлдвэр, гар урлалын цехүүдийг нээж, туслах үйлдвэрлэлийг аль болохоор хөгжүүлж байна. Жишээ нь Ханойгоос холгүй орших Суан Тьен хоршоолол гэхэд л бүх өрхийн 70 орчим хувь нь үндсэн ажлынхаа хажуугаар оёх, нэхэх, барилга барих, тоосго цохих, мужаан хийх, мод төмрөөр хөдөлмөрчдийн өргөн хэрэгцээний зүйлс хийж борлуулах зэргээр туслах аж ахуй эрхэлж байна.

3. Аж үйлдвэрийн салбар дахь шинэчлэл

Энэ салбарт 80-аад оноос шинэчлэлийн анхны алхамууд хийгдэв, Вьетнамын аж үйлдвэрийн салбарт тохиолдож байгаа гол бэрхшээл гэвэл материал түүхий эдээр ноцтой дутагдаж байгаа явдал юм.

Сайд нарын Зөвлөлийн 1981 оны 25-р тогтоолоор үйлдвэрийн газар материал, түүхий эдийн нөөцөө бие даан нэмэгдүүлэх, орон нутгийн аж ахуйн газруудтай гэрээ хийж, материал, түүхий эдийн зарим хэсгийг хангаж болохыг заав. Үүнтэй уялдуулан 80-аад оны эхнээс үйлдвэрийн газрууд материал болон цахилгаан эрчим хүчээр өөрийгөө хангасан нөхцөлд үндсэн болон дайвар бүтээгдэхүүнийг улсын төлөвлөгөөнөөс давуулан үйлдвэрлэж өөртөө ашиглахыг хөхүүлэн дэмжив. Үүний дагуу материал түүхий эдийг үйлдвэрийн газар бие даан олохдоо хоршоолол буюу хувийн пүүс, иргэдтэй тохиролцсоны үндсэн дээр авч болохыг заажээ. (Энд улсын хэмжээгээр үнийн бодлого боловсронгуй болж чадаагүй байгаа явдал тодорхой бэрхшээл учруулсаар байна).

Одоо БНСВУ-ын үйлдвэрүүд улсын материал, түүхий эдээр үйлдвэрлэсэн улсын даалгавартай бүтээгдэхүүн, үйлдвэрийн өөрийн материал, түүхий эдээр хийсэн үндсэн бүтээгдэхүүн, мөн өөрийн материал түүхий эдээр хийсэн дайвар II бүтээгдэхүүн гэсэн 3 төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна. III бүтээгдэхүүнийхээ үнийн 10% -ийг үйлдвэрийн шагналын фондод үлдээж болохоос гадна удирдах дээд байгууллагатай зөвшилцсөний үндсэн дээр II бүтээгдэхүүний

зарим хэсгийг үйлдвэрийн газрын эрх ашгийн үүднээс (материал түүхий эдээр солих гэх мэт) өөр үйлдвэрийн газарт худалдаж болох ажээ. Энэ нь үйлдвэрийн газрыг эдийн засгийн өрсөлдөөний механизмд оруулах, үйлдвэрлэлийн зах зээлийн нөхцөлд чиглүүлэх боломж олгож байна.

Одоо БНСВУ-ын үйлдвэрийн газрууд өөрийн хүчин чадал, боломжинд тулгуурлан төлөвлөгөөг бие даан боловсруулах, орлого, зээл ашиглах замаар хөрөнгө оруулалтын эх үүсвэр бий болгох эрхтэйгээс гадна үйлдвэрийн ажилчин албан хаагчдыг халах, солих, орон тоог нэмэх, цөөлөх бүрэн эрхийг гартаа авчээ.

Шинэчлэлийн явцад тоног төхөөрөмж, материал, хөдөлмөрийн нөөцийг зөв ашиглах, хөрөнгө оруулалтыг үр ашигтай болгох сонирхол бий болж байна. Ажилчдын орлого нэмэгдэж, үйлдвэрийн газруудын хөдөлмөрийн бүтээмж мэдэгдэхүйц (10%) дээшилж байгаа ажээ.

Гэвч үлэмжхэн бэрхшээл учирсаар байна. Юуны өмнө үйлдвэрийн газруудын эрхийг өргөтгөж байгаа ч гэсэн яам тусгай газрууд захиргаадах арга барилаасаа салахгүй байгаа учир үйлдвэрийн газруудад эдийн засгийн удирдлагын систем бүрэн хэрэгжихгүй байна. Үйлдвэрийн газрууд материал түүхий эд, тоног төхөөрөмжөөр дутмаг байгаа нь үйлдвэрлэлийг өргөжүүлэх боломжгүй болгож, улмаар ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд бэрхшээл учруулж байна. Одоо БНСВУ-д шинжлэх ухаан-техникийн ололтыг үйлдвэрлэлд аль болох өргөн нэвтрүүлэхийг чухалчилж байна. Үүнтэй холбогдуулан шинжлэх ухаан, техникийн шинэ бүтээл, оновчтой санал гарган үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд хувь нэмэр оруулбал түүний үр дүнг тооцон нийт орлогын 15—20%-ийг уг эзэнд олгох шийдвэр гаргажээ.

Улсын томоохон үйлдвэрийн зэрэгцээ хоршооллын болон хувийн жижиг үйлдвэрлэл Вьетнамын ардын аж ахуйд чухал суурь эзэлж байна. 80-аад оны байдлаар энэ салбар аж үйлдвэрийн нийт бүтээгдэхүүний 40 орчим хувийг, түүний дотор өргөн хэрэгцээний барааны 60 гаруй хувийг мөн экспортын барааны үлэмж хувийг үйлдвэрлэн гаргаж байна.

Хоршооллын болон хувийн жижиг үйлдвэрийн нэгжүүдэд материал, хэрэгслийг улсын үнээр зарахаас гадна түүний бүтээгдэхүүнийг тохиролцсон үнээр нь аж ахуйн гэрээний үндсэн дээр улс худалдан авдаг бөгөөд жижиг үйлдвэрлэлийг эрхэлдэг хувь хүмүүс бараа эргэлтийн улсын бодлогод тохируулан бүтээгдэхүүнээ чөлөөтэй борлуулах эрхтэй болж байна.

Хувийн болон хоршооллын жижиг үйлдвэрлэл эрхлэгчид улсаас зээл авах, банканд тооцоо нээх эрхтэй юм. Үйлдвэрлэлийн энэ салбарт ч шинжлэх ухаан, техникийн ололтыг нэвтрүүлэхийг улсаас хөхүүлэн дэмжиж байна. Хувийн үйлдвэр эрхлэгчдэд 5—10 хүртэл хүнийг гэрээгээр хөлслөн ажиллуулах эрх олгожээ.

Насны тэтгэвэрт гарсан хүмүүсээс гадна улсын болон хоршоололын секторт ажиллагсдаас хувиараа хөдөлмөр эрхэлж өргөн хэрэгцээний барааг үйлдвэрлэх, үйлчилгээний хүрээг өргөтгөхөд гар бие оролцохыг дэмжиж зарим хөнгөлөлт үзүүлж эхэлж байна. Тухайлбал тэдний орлогоос авах татварыг эхний бүтэн жилийн хугацаанд чөлөөлөх, зээл, түүхий эд олгох, цахилгаан эрчим хүчийг хөнгөлттэй үнээр хэрэглүүлэх боллоо.

БНСВУ-д экспортын барааны хэмжээг бүх талаар нэмэгдүүлэх зорилтыг ВКН-ын VI их хурлаас дэвшүүлсэн билээ. Үүнтэй холбогдуулан зарим арга хэмжээг авч байна. Юуны өмнө бүх ард түмнийг экспортын бараа үйлдвэрлэхэд татан оролцуулахын тулд улсын болон хоршооллын, мөн хувийн үйлдвэрийн газруудад экспортын бараа үйлдвэрлэж гадаад зах зээлд шууд гарах эрх олгожээ. Эдгээр үйлдвэрийн газрууд нь (чухал материал, түүхий эд, тоног төхөөрөмж авахад зориулж) валютын орлогын зарим хэсгийг өөртөө ашиглах эрхтэй бөгөөд улсынх ч бай хувийнх ч бай бүх үйлдвэрийн газрууд экспортоос олсон орлогоо авахдаа эн тэгш эрхтэй юм. Хоршооллын болон хувийн үйлдвэрийн экспортын зарим бүтээгдэхүүнийг татвараас чөлөөлсөн буюу хөнгөлсөн нь улс орны экспортын хэмжээг нэмэгдүүлэхэд түлхэц болж байна.

Урьд, улсын бүх гадаад худалдаа, хангамжийн асуудлыг Гадаад худалдааны яам гартаа төвлөрүүлж байсан нь улс орны хөгжлийг зогсонги байдалд оруулахад багагүй нөлөөлж байжээ. Үүнээс гарахын тулд үйлдвэрлэл-худалдааны пүүсүүдийг байгуулж, гадаад зах зээлд шууд гардаг болгосон нь экспортын хэмжээг нэмэгдүүлж, гадаадын худалдан авагчдын хүсэл сонирхолд нийцсэн барааг түргэн шуурхай үйлдвэрлэж нийлүүлэх, сонирхлыг үлэмж нэмэгдүүлснээс гадна орчин үеийн тоног төхөөрөмжийг цаг алдалгүй олж үйлдвэрлэлд нэвтрүүлэх таатай нөхцөл бүрджээ. Одоо Вьетнамын нийт мужийн тавны нэг нь (өөрийн боомт усан онгоцыг ашиглан) гадаад зах зээлд шууд гарч үйлдвэрийнхээ бүтээгдэхүүнийг борлуулах, шаардлагатай тоног төхөөрөмжөө олж авах ажлыг бие даан гүйцэтгэж байна. Гадаад худалдааны яам дээрх ажлыг хянах, зөвлөх, бодлого чиглэл боловсруулах ажилд гол анхаарлаа чиглүүлж байна. Гадаад худалдааны ачаар загасны аж үйлдвэр, нэхмэлийн үйлдвэр, тамхи, каучукийн аж ахуйнууд зогсонги байдлаас гарч техник тоног төхөөрөмжөө орчин үеийн болгож амжжээ.

Сүүлийн үед засаг захиргааны олон нэгжүүд тухайлбал Ханой, Хошимин, Хайфон хотууд, Куангнам-Дананг, Хайзянг, Миньхай зэрэг мужууд экспорт, импортыг хөгжүүлэхэд тогтвортой амжилт олж байгаа ажээ.

Загасны аж ахуй, хөдөө аж ахуй, хөнгөн, хүнсний аж үйлдвэр, машин-металлург, нүүрсний аж үйлдвэрүүд улсад валютын үлэмжхэн орлого оруулж байна.

Урьд үйлдвэрийн газруудын хөрөнгө оруулалтыг үндсэндээ дээрээс төлөвлөж төвөөс хуваарилдаг байсан бол одоо шаардлагатай хөрөнгийг юуны өмнө үйлдвэрлэлийн хамт олон өөрсдөө олж авах ёстой болжээ. Үүнээс гадна хөрөнгө оруулалтын шинэ хуулийн дагуу гадаад орнуудаас багагүй хөрөнгө оруулж байна.*

Гадаадаас оруулж байгаа хөрөнгийг гол нь эдийн засгийн томоохон объектуудыг барьж байгуулах экспортын болон өргөн хэрэгцээний барааны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, үйлдвэрлэлийн дэд бүтцийг төгөлдөржүүлэхэд чиглүүлж байна. Үүнд хөрөнгө оруулалтын олон хэлбэрийг ашиглаж байгаа бөгөөд гэрээний үндсэн дээр хоёр талаас хамтран хөрөнгө оруулж хамтын үйлдвэр, үйлдвэрлэлийн хоршоолол

* 1989 оны эхний байдлаар гадаадын хөрөнгө оруулалтын нийт хэмжээ 50 сая долларт хүрчээ.

байгуулж ашиг орлого хуваан ашиглах хэлбэрийг өргөн хэрэглэж байна. Гадаадаас хөрөнгө оруулагчдын оруулах хөрөнгийн дээд хэмжээнд хязгаар тавиагүй бөгөөд харин доод хэмжээг 30 хувиар тогтоожээ. Үйлдвэрийг хамтын хөрөнгөөр барьж болохоос гадна вьетнамын нутаг дэвсгэр дээр гадаадын пүүсүүд дангаараа хөрөнгө оруулж үйлдвэрлэл явуулахыг ч зөвшөөрч байна. Ийм тохиолдолд эдгээр үйлдвэрийн орлогоос зохих хэмжээний татвар авах бөгөөд өөрийн түүхий эд, хөдөлмөрийн нөөцийг ашиглуулах ажээ. Мөн цэвэр гадаадын хөрөнгөөр барьсан хамтын үйлдвэр ч байж болох ажээ. Гадаадын пүүсүүд оролцсон хамтын болон дагнасан үйлдвэрүүдийн ажиллах хугацааг 20 жилээс хэтрэхгүй байхаар төлөвлөж байна. Харин орлого багатай байгаа салбарын үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хугацааг сунгаж болох ажээ.

Гадаадаас хөрөнгө оруулагчид нь валютаар буюу вьетнамын Засгийн газрын сонирхож байгаа ямар ч зүйлээр (тоног төхөөрөмж, машин техник, барилга байгууламж гэх мэт) хөрөнгө оруулж, Вьетнамын тал гол нь өөрийн үндэсний мөнгө (донг), байгалийн түүхий эд, ашигт малтмал, материал, барилга байгууламж, зам талбай, тоног төхөөрөмж гэх мэт зүйлээр хөрөнгө оруулж байна. Эдгээр үйлдвэрийн газруудад вьетнамын ажилчдыг ажиллуулах бөгөөд техникийн нарийн мэргэжил шаардсан зарим ажлын байранд гаднын ажилчныг түр ажиллуулж болох ажээ. Хамтын үйлдвэрүүд нь тус орны экспортын барааны хэмжээг үлэмж нэмэгдүүлэхэд чиглэгдэж байгаагаас гадна үйлдвэрлэлд тэргүүний технологи нэвтрүүлж техникийн сэтгэлгээг хөгжүүлэхэд бас тус дөхөм үзүүлэх ажээ. Хөдөлмөрийн нөөц ихтэй, байгалийн баялагаар муугүй, улс төрийн байгууллын хувьд тогтвортой усан замын ашигтай байршилтай энэ оронтой гадаадын пүүсүүд хамтран ажиллах багагүй сонирхолтой байна. Үүнд Вьетнамын талаас санаачилж байгаа зарим хөнгөлөлт ч нөлөөлж байна. Тухайлбал, гадаадын хөрөнгө оруулагчдаас авах татварын хэмжээг харьцангуй бага тогтоож байгаа нь тэдний орлогын хэмжээг нэмэгдүүлэх боломж олгож байна. Орлогын татварын хувьд нийт орлогын 15—25 хувьтай тэнцэж байна. Нефть, шатдаг хий болон бусад үнэт буюу ховор ашигт малтмалын хувьд татварын хэмжээ харьцангуй өндөр юм. Харин зам харилцаанаас алслагдсан районд байгуулсан үйлдвэрийн болон бусад аж ахуйн газрын татвар 10% хүртэл бага байна.

Хөрөнгө оруулалтын цар хэмжээ, үйлдвэрлэж байгаа экспортын бүтээгдэхүүний шинж чанар, үйлдвэрийн газрын үйл ажиллагааны хугацаа зэргийг харгалзан зарим хамтын үйлдвэрийн газрыг эхний хоёр жил татвараас чөлөөлж, дараахь хоёр жилд нь татварын хэмжээг 50 % хүртэл бууруулж болох ажээ.

Хамтран ажиллаж байгаа гадаадын пүүсүүдэд үйлдвэрлэлээ явуулахад нь аль болох тохиромжтой нөхцөл бүрдүүлэх ажээ. Тэдний оруулсан хөрөнгө, үйлдвэрлэлийн хэрэгсэл зэргийг хууль бусаар хураан авч, улсын болгохгүй байх баталгааг өгч байна.

Орлогынхоо хэсгийг улс орондоо шилжүүлэхдээ бусад орнуудтай харьцуулахад мөн л харьцангуй бага татвар төлөх ажээ. (5— 100%). Вьетнамд гадаадаас хөрөнгө оруулах тухай шинэ хууль батлагдсаны (1987. XII) дараахнаас эхлэн гадаадын олон пүүс хөрөнгө оруулж хамтын үйлдвэр байгуулах сонирхолтой байгаагаа илэрхийлжээ. Юуны өмнө ах дүү орнуудтай (ЗХУ, Герман, Чех, Болгар гэх мэт) нефть,

шатдаг хий, загас олборлох, каучук, кофе, цайны тарималын хамтарсан үйлдвэр, аж ахуйн газар байгуулж эхэлсэн туршлагаа улам гүнзгийрүүлж үр ашигтай болгож байна. Үүний зэрэгцээ социалист биш олон орны пүүстэй хамтын үйлдвэр байгуулж эхэллээ. Жишээ нь Вьетнамын жуулчдыг үйлчлэх газар Гонгконгийн жуулчны «Хотримекс» пүүстэй хамтран гадаадын жуулчдыг үйлчлэх хамтын байгууллага байгуулав. Хоёр тал адил тэнцүү хувь нийлүүлж, орлогоо тэнцүү хуваах ажээ. Мөн Тайландын пүүстэй хамтран далайн гаралтай хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэж гадаадад гаргах болжээ. Үүнээс гадна Гонгконг, Сингапуртай хамтран оёдлын үйлдвэр байгуулж бүтээгдэхүүнээ гадаадад гаргахыг тохиролцжээ. Эдгээр орны пүүсүүдэд тоног төхөөрөмж, материалыг авчрах, мөн олсон орлогоосоо нутаг руугаа илгээхэд нь хөнгөлөлт үзүүлэх ажээ. Вьетнамд нефть, шатдаг хийн хайгуул хийж, хамтран олборлох гэрээг Энэтхэг, Голланд, Бельгийн пүүсүүдтэй хийж байна. Эдгээр пүүсүүд хөрөнгө оруулалтыг дангаар хийж, хайгуул амжилтгүй болох тохиолдолд алдагдлыг өөртөө хүлээ. Хээр тохирчээ. Хэрвээ нефть, шатдаг хий илрүүлж чадвал бүтээгдэхүүнээ харилцан ашигтайгаар хуваан олборлох ажээ.

Мөн Испанитай хамтран нефть боловсруулах үйлдвэр, суудлын машин угсрах завод, эрүүлийг хамгаалах төв, ган цувих цех, нарны эрчим хүчийг ашиглах төв зэргийг барьж байгуулахаар тохирчээ.

Япон, Франц, Швед, Канад, Сингапур, Тайланд, Австрали зэрэг орны пүүсүүд хамтран ажиллах бололцоог судалж байна. Энэ бүхэн нь социалист орнуудтай хийх худалдаа эдийн засгийн харилцааг багасгахгүй харин ч нэмэгдүүлэх нөхцөлийг бий болгоно гэж үзэж байна. Учир нь экспортын чиглэлийн хамтарсан үйлдвэрүүд эхэлж байгуулж байж сая гадаад зах зээлд борлуулах бараагаа нэмэгдүүлж эдийн засгийн харилцааг аль ч оронтой хөгжүүлэх боломж буй болгох ажээ.

Ийнхүү БНСВУ эх орныхоо эдийн засаг, хөдөлмөрийн нөөц бололцоог ашиглан экспорт импортын хэмжээг нэмэгдүүлж, олон улсын эдийн засгийн хуваарьт идэвхтэй оролцох шийдэмгий алхам хийж эхэллээ.

ВКН-ын VI их хурлаас хойших хугацаанд нийгмийн бодлогыг хүчтэй болгож, нийгэм улс төрийн шинэ уур амьсгал бий болгон ардчилал, ил тод байдлыг гүнзгийрүүлэх, нам, төрийн байгууллагуудын боловсон хүчний ажлын арга барилыг шинэчлэн өөрчлөхөд их анхаарч байна. Энэ нь Вьетнам дахь эдийн засгийн шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чухал түлхэц болж байна. Энэ бүхний үр дүнд БНСВУ 60, 70-аад онд хуримтлагдсан эдийн засгийн үлэмж бэрхшээлийг даван туулах, социалист аж ахуйн механизмыг улам боловсронгуй болгох, социалист нийгмийн давуу талыг аль болох бүрэн дүүрэн ашиглах улмаар тус орны социалист байгуулалтын тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх чиглэлд буцалтгүй алхам хийсээр байна. Гэвч Вьетнамын эдийн засгийн өнөөгийн байдал хүнд хэцүү хэвээр байгааг вьетнамын хэвлэлд ил тод бичсээр байна. Тус улсын эдийн засаг өргөн хэрэгцээний бараагаар ард түмнээ хангаж чадахгүй, улсын төсвийн хувьд орлого нь зарлагаа нөхөхгүй, экспорт импортын баланс алдагдалтай, үндэсний эдийн засгийг хөгжүүлэх дотоод нөөцгүй байгааг тэмдэглэж байна.

Ийм нөхцөлд улс орноо хүнд байдлаас гаргаж, социалист байгуулалтыг түргэтгэх ухаалаг бөгөөд чухал зам нь шинэчлэлийн үйл явцыг эргэлт буцалтгүй гүнзгийрүүлэх явдал хэмээн үзэж байна. Үүнтэй холбогдуулан ВКН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Ван Линь 1987 оны 12-р сард хуралдсан Намын Төв Хорооны IV бүгд хурал дээр хэлэхдээ: «Хамгийн гол нь бид хүнд байдлаас гарах арга замыг олж харсан бөгөөд энэ нь биднийг зоригжуулж, баттай итгэл төрүүлж байна. Энэ бол өнөөгийн нөхцөлд бидний хувьд хамгийн чухал, хамгийн гол зүйл мөн. Чухамхүү энэ нь бидний цаашдын эрс шийдэмгий үйл ажиллагааны тулах цэг болох ёстой»¹⁰ гэжээ.

Нийгмийн хөгжлийн бодит шаардлагаас урган гарсан шинэчлэлийн бодлогыг вьетнамын олон сая ард түмэн идэвхтэй дэмжиж байна. Энэ нь БНСВУ дахь шинэчлэлийн үйл явц амжилтанд хүрэхийн бодит баталгаа мөн.

1. Буруу тодорхойлбоос субъективизм, волюнтаризмд халтиран ордог түүхэн сургамжийг иш үндэс болгож буй ажээ.
2. Tran Kham. May van de ly luan ve thoi ky qua do len chu nghia xa hol. -- vietnam, Hanoi, 1983, 138 tr. (Вьетнам дахь шилжилтийн үеийн тухай онолын зарим асуудал)
- Mot so van de ly luan va phuong phap luan nghien cuu thoi ky qua do o' Vietnam. Hanoi, 1986. 172 tr. (Вьетнамын шилжилтийн үеийг судлах онол аргагүйн зарим асуудал). — ВКН-ын VI Их хурлын материал
- 1982 оны IX сарын ВКН-ын Улс төрийн товчооны хурлын тогтоол.
3. Van kien Dai hoi dai bieu toan quoc lan thu VI. Hanoi. tr. 19. 1986,
4. Мөн тэнд.
5. Tong tin khoa hoc xa hoi, Hanoi, 1985, N 6 tr, 32, (Нийгмийн шинжлэх ухааны мэдээ)
6. Шилжилтийн үеийн төгсгөлийн шатанд 1) Социалист сектор үйлдвэрлэлийн бүх салбарт зонхилж гол үүрэг гүйцэтгэх; 2) Социалист үйлдвэрлэлийн харилцаа үлэмж боловсронгуй болж, социалист эдийн засгийн зарчмууд бүрэн хэмжээгээр үйлчлэх, 3) Социализмын материал-техникийн баазыг үндсэн гол үзүүлэлтээр байгуулж дуусгах үндсэн зорилтыг хэрэгжүүлнэ гэж вьетнамын судлаачид үзэж байна. Tap chi song sang, 1987. N3 tr. 26,
7. Вьетнамын умард нам дор газрын га-аас авах ургацын дундач хэмжээ 2,5—4,2 тонн ажээ.
8. Currier du Vietnam. 1986, p. 8
9. Мөн тэнд p.10
10. Bai phat bieu cua d/c Tong Bi thu Nguyen Van Linh tai Hoi nghi lan thu VI BCHTU0 /Khoa V1./ (Төв Хорооны IV бүгд хурал дээр ВКН-ын Төв Хорооны ерөнхий нарийн бичгийн дарга Нгуен Ван Линь-ий хэлсэн үг)